

# The Baptist Tabernacle of Los Angeles

Mailing Address:  
P. O. Box 15308  
Los Angeles, CA 90015  
Phone: (213) 744-9999

E-mail: [rhymersjr@sbcglobal.net](mailto:rhymersjr@sbcglobal.net)  
[www.sermonsfortheworld.com](http://www.sermonsfortheworld.com)  
[www.baptisttabernacle.com](http://www.baptisttabernacle.com)



Jack Ngann  
Pastor

Dr. R. L. Hymers, Jr.  
Pastor Emeritus

Арван хоёрдугаар сар, 2021

Эрхэм анд минь:

Бидний туулсан зовлон сорилтууд хичнээн их ч Бурханы сайн сайхан нь түүнээс хавьгүй илүү! Энэ оны нэгдүгээр сард миний бурханлаг хайрт хань Илеана коронавирусээр эерэг гарсан. Би түүнийг үхэж магад гэж бодсон. Манай чуулган түүний төлөө маш олон удаа залбирсан. Мөн дэлхий даяар байгаа пасторууд болон бусад Христ итгэлтэнүүд маань түүний төлөө залбирч, түүнийг тайвшруулах болон дэмжсэн чатуудыг илгээж байсан. Пакистан дахь нэг номлогч өглөө бүр дэлхийн нөгөө талаас түүн рүү утсаар ярьж байсан! Бурхан хариулсан, эхнэр маань бүрэн эдгэрсэн! Түүний төлөө залбирсан бүх хүмүүсийн төлөө миний талархал урссаар байна.

Миний амьдралын эшлэл бол үргэлж л Филиппой 4:13 байдаг. Би үүнийг өмнөх эшлэлтэй нь хамт та нарт өгье. Библи ийнхүү хэлдэг,

“Би тарчигхан байхыг ч мэднэ, элбэг дэлбэг байхыг ч мэднэ. Ямар ч, аливаа нөхцөл байдалд өлсгөлөн болон цатгалан байх, дутагдах, элбэг байхын аль алины нууцад би суралцсан. Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна.” (Филиппой 4:12, 13).

Бурхан намайг болон Илеанаг өвчтэй байх үед хүчирхэгжүүлсэн. Мөн түүнийг эдгээснийх нь төлөө Бурханд алдарыг өргөн баярлан хөөрч байхад Христ биднийг бас хүчирхэгжүүлсэн. “Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна.”

Гуравдугаар сарын 24-ний өдөр Лос Анжелес хотын төв дэх манай хуучин байрны худалдаатай холбоотой эскроу данс эцэст нь суллагдсан. Одоо тэр байр нэгэн Солонгосын чуулганы өмч болсон. Тэр суларсан мөнгө нь манай Сан Габриел дэх шинэ чуулганы барилгыг сайжруулахад зарцуулагдаж байгаа. Жак Нганн “Хятад Баптист Табернэкл Агуу Лос Анжелес” шинэ чуулганы пастор байх болно.

Дөрөвдүгээр сарын 11-ний өдөр тансаг Беверли Хилтон Зочид Буудалд миний 80 насны ойгоор бид цугларч дараагийн өдөр нь хүртэл байсан. Дэлхий даяарх олон номлогчид болон Христ итгэлтэнгүүдээс төрсөн өдрийн мэндчилгээ ирсэн. Манай том хүү Роберт Леслие хүндэтгэлийн арга хэмжээний хоол болон бусад холбоотой бүх зардлыг гаргасан. Роберт бол ухаантай, амжилттай бизнесмэн хүн. Доминикан улсын Бетсайд Христиан Чуулганы пастор Рев.Руперто Медина энд нисэж ирээд нээлтийн залбирал хийсэн. Бид үнэхээр гайхалтай цагийг хамтдаа өнгөрөөсөн!

Тавдугаар сарын 3-нд манай [www.sermonsfortheworld.com](http://www.sermonsfortheworld.com)-д Одиа хэлээр манай номлолууд тавигдаж эхэлсэн. Одиа бол Энэтхэгийн олон хэлний нэг юм. Ойролцоогоор 30 сая хүн энэ төрөлх хэлээрээ одоо ярьж байгаа. Миний хүсэл бол зөвхөн аль болох олон хэлээр дэлхий даяар Сайнмэдээг

**МАНАЙ НОМЛОЛЫН ВЕБСАЙТ НЬ 46 ХЭЛЭЭР ҮГ БҮРЧЛЭН ОРЧУУЛСАН ХЭДЭН  
ЗУУН НОМЛОЛУУДЫГ [WWW.SERMONSFORTHEWORLD.COM](http://WWW.SERMONSFORTHEWORLD.COM)-ООР  
САНАЛ БОЛГОЖ БАЙГАА.**

түгээхэд байдаг. Тийм учраас номлолуудын маань бичвэр зохиогчийн эрхгүй байдаг бөгөөд тэд хүссэнээрээ эдгээрийг ашиглаж, бас байгаагаар нь номлож болно. Долоо хоног бүр дэлхийн өнцөг булан бүрээс энэ номлолыг ашиглах боломж олгосон минь баярлалаа гэсэн талархалыг хүлээж авдаг.

Тавдугаар сарын 14-нд агуу зүйл тохиосон. Манай ач хүү Роберт Леслие Химерс IV мэндэлсэн! Тэр бол миний хүү Роберт болон түүний гэргий Жиний хүү юм. Тэд мөн өөр Ханна болон Сара гэсэн хоёр охинтой. Шинэ төрсөн хүүхэд бол бидний анхны бөгөөд цорын ганц ач хүү юм. Би түүнийг “Бяцхан Боб” хэмээн дууддаг. Тэр бол сайн хүн бөгөөд Бурхан түүнийг номлогчоор дуудах болтугай хэмээн би залбирдаг!

Христ намайг сайн хийгээд зөвүүн цагуудад ч, цагалан хийгээд өлсгөлөн үед ч, элбэг дэлбэг хийгээд ядуу тарчиг үед ч хүчирхэгжүүлсээр байгаа. Зургаадугаар сард би цус харвасан. Түүнээс хойш би гэртээ амрах болсон. Надад тусалдаг мэргэжлийн асрагч байгаа боловч миний хамгийн сайн туслагч бол миний хань Илеана юм. Юу ч боллоо гэсэн ирээрэй, би хэзээ ч Сайнмэдээний үйлчлэлээсээ бууж өгөхгүй. Долоо хоног бүр би чуулгандаа үзүүлэхээр видео мессеж бичлэг хийгээд манай вебсайтад үзүүлдэг. Миний амьдралын туршид Христ намайг хүчирхэгжүүлдэг!

Би чуулгандаа үргэлж л Марилин Фарникийн түүхийг ярьсан. Олон жилийн өмнө тэр хойд Сан Францискогийн Марин Соунтид өсвөр насны охин байсан. Марилин Есүст найддаг байсан. Түүний ээж нь Марилиныг хар тамхи татаж, хөвгүүдтэй секс хийвэл бараг сэтгэл хангалуун байхаар байсан – гэхдээ энэ ээж энэ Христээс тусгаар байхыг хүсдэг байсан! Тэр Марилиныг гэрээсээ хөөсөн. Марилин Аврагчдаа итгэсэн хэвээр үлдсэн. Одоо тэр өөрийн нөхөр Жерритэй хамт Чех улсад мишшионероор амьдарч байгаа. Наймдугаар сарын 26-нд Жерри болон Марилин манай гэрт над дээр зочилж ирсэн. Тэдний өөрийнхөө үйлчлэлийн талаар танилцуулгыг бичлэг хийгээд чуулгандаа үзүүлсэн. Тэд үнэхээр гайхалтай байсан! Аврагдсан хүмүүс дэх Бурханы нигүүлсэл хийгээд Бурхан тэднийг үйлчлэлдээ ашиглаж байгааг харах нь хичнээн сайхан гээч. Элч Иохан хэлсэн шиг, “Миний хүүхдүүд үнэн дотор явж байгааг сонсохоос эрхэм баяр баясгалан гэж надад байхгүй билээ.” (III Иохан 4).

Наймдугаар сарын 29-нд Жак Нганн манай шинэ пастораар танилцуулагдсан. Жак бол Америкийн иргэн бөгөөд хятад хүнээр төрсөн. Тэр гэрлэсэн бөгөөд хоёр хүүхдийн эцэг. Би бол Емеритусын Пастор, яг л миний пастор Др Тимоти Лин намайг сургасан шиг би түүнийг пасторын ажилд сургаж байгаа. Нганн дүү маань үнэхээр сайн итгэгч бөгөөд бид түүнд их найдвар тавьж байгаа. Та нар манай шинэ чуулган хийгээд түүний тэнд дэх үйлчлэлийнх нь төлөө залбирч өгөөрэй.

Есдүгээр сарын 22-нд Сан Габриел дэх бидний чуулганы шинэ байранд барилгын засварын ажлыг эхлүүлсэн. Барилга дараагийн жилийн эхэнд ашиглахад бэлэн болж байгаа. Энэ нь хэдэн мянган Хятад хүмүүс оршидог дүүргийн дунд оршдог.

Аравдугаар сард Илеанагийн аав Рафаел Куеллар Гуатемалаагаас нисэж ирээд манай гэрт хэдэн долоо хоног хамт байсан. Тэр бол жинхэнэ эр хүн бөгөөд маш сэргэлэн, идэвхтэй – тэр 90 гарсан настай гэдгийг хэрвээ чи мэдвэл бодож байгаагаас чинь илүү залуу харагдана! Түүний 91 насны төрсөн өдрийг энэ Аравдугаар сарын 29-нд манай гэрч чуулганыхантай хамт тэмдэглэсэн.

Арваннэгдүгээр сарын 21-нд Их Талархалын баярыг манай гэрч бүх чуулганаараа хийсэн. Энд хоол нь үнэхээр амттай байсан! Бидний магтаал хоол хийж, оройн хоол бэлдсэн Илеана, Жак Нганн, болон манай ахлагч Мануел Менсиа нар руу урсаж байсан.

Энэ бол үнэхээр сайхан жил байсан! Бүх алдрыг бид залбиралд минь хариулсан Бурхандаа болон бидний сэтгэлийг аварсан Христэд өгч байгаа. Би 1991 онд Шотландын Гласгов дахь Билли Грахамын арга хэмжээн дээр Жорж Биверли Шеагийн дуулсан дууны үгсийг бодож байна,

Баярлалаа Танд, Өө миний Аваа, бидэнд Өөрийн Хүүгээ өгсөнд  
Мөн Өөрийн Сүнсээ ертөнц дэх ажил дуусах хүртэл хамт үлдээсэнд.  
("Аврагч байна" Keith Green, 1953-1982).

**МАНАЙ НОМЛОЛЫН ВЕБСАЙТ НЬ 46 ХЭЛЭЭР ҮГ БҮРЧЛЭН ОРЧУУЛСАН ХЭДЭН  
ЗУУН НОМЛОЛУУДЫГ [WWW.SERMONSFORTHEWORLD.COM-OOP](http://WWW.SERMONSFORTHEWORLD.COM-OOP)  
САНАЛ БОЛГОЖ БАЙГАА.**

Бид Аврагчийнхаа төрсөн өдрийг тэмдэглэж байгаа шиг чангаар “Баярлалаа, Таньдаа, Эзэн Бурхан минь, Есүс Христ магтагдах болтугай!” хэмээн хашгирцгаая.



Би нэгдүгээр эгнээний голд өөрийнхөө зээ охидтойгоо байна, миниф зүүн талд Ханна, баруун талд Сара, зүүнээс баруун тийш Илеанагийн аав Рафасл Куеллар, Илеанагийн ээж Линда, Роберт Леслигийн гэргий Жин, бяцхан Боб аав Робертоороо тэврүүлсэн, миний гэргий Илеана, бидний хүү Весли, Илеанагийн эгч Иветте Куеллар.

Есүсийн нэр дээр танд мэндчилсэн,

Рев. Р.Л Химерс Жр.,  
D.Min., D.Rel., Th.D., Litt.D.  
Филиппой 4:13

***МАНАЙ НОМЛОЛЫН ВЕБСАЙТ НЬ 46 ХЭЛЭЭР ҮГ БҮРЧЛЭН ОРЧУУЛСАН ХЭДЭН  
ЗУУН НОМЛОЛУУДЫГ WWW.SERMONSFORTHEWORLD.COM-ООР  
САНАЛ БОЛГОЖ БАЙГАА.***